



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.14 № 1/08

Төсвийн орлого болгох тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Замын-Үүд" ЭЗЧБ-ийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

"Замын-Үүд" ЭЗЧБ-ийн захирагчийн 2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн №А/43 тоот захирамжаар тус чөлөөт бүсийн ажилтан Н.Шаравдоржыг 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс 23-ны өдрийг хүртэл "Замын-Үүд" сум руу 3 өдрийн дотоод томилолт, БНХАУ-ын Эрээн хот руу 2 өдрийн гадаад томилолтоор ажиллуулахаар томилсон байна. Гэтэл тухайн томилолтоор ажилласныг нотлох анхан шатны баримтаар гадаад паспортын хуулбарыг хавсаргасан байх ба 2013 оны 11 сарын 22, 24-ны өдрүүдэд Монгол Улсын хилээр нэвтэрсэн байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх" 20.1.4-т "хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1-т "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Замын үүд" ЭЗЧБ-ийн ажилтан Н.Шаравдоржын томилолтоор ажилласан нь нотлогдохгүй байгаа 540.8 мянган төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 900000601 дугаар дансанд 2014 оны 04 дүгээр сарын 1-ний дотор буцаан төвлөрүүлэх
2. Төлбөрийг барагдуулж, биелэлтийг 2014 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирагч Д.Батсайхан, нягтлан бодогч С.Эрдэнэбаатар нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын шинжээч
Н.Нямдаваа
"Улаанбаатар аудит корпораци" ХХК-ийн
Ерөнхий захирал Б.Осоргарав

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН

"Замын үүд" ЭЗЧБ-ийн захирагч
Д.Батсайхан
Ерөнхий нягтлан бодогч
С.Эрдэнэбаатар